

ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ПАРЛАМЕНТЫН ХУУЛЬ ТОГТООХ БҮРЭН ЭРХТЭЙ ХОЛБООТОЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

(Мэдээлэл, лавлагаа)

Г.Билгээ

1.БНКАЗАХСТАН УЛСЫН ПАРЛАМЕНТ БОЛОН ТҮҮНИЙ ДЕПУТАТУУДЫН ТУХАЙ ХУУЛЬ²⁸⁹

46 дугаар зүйл. Өмнөх бүрэн эрхийн Жогорку Кенешийн чуулганаар батлаагүй хуулийн төслүүд

1.Хэрэв депутат, эсхүл депутатуудын санаачилсан хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг өмнөх бүрэн эрхийн Жогорку Кенешийн чуулганаар хийгээгүй бол уг хуулийн төслийг гэж үзнэ. Үүнд олон нийтийн саначлагаар өргөн барьсан хуулийн төсөл хамаарахгүй.

2.Хэрэв өмнөх Засгийн газраас өргөн мэдүүлсэн хуулийн төслийг шинэ Засгийн газар дэмжихээс татгалзсан бол уг хуулийн төслийг татан авсан гэж үзнэ.

3.Депутат, эсхүл депутатуудын санаачилсан хуулийн төслийг татан авсан тохиолдолд шинээр сонгогдсон Жогорку Кенешийн депутатууд болон Жогорку Кенешийн хариуцагч хороо уг хуулийн төслийг дахин санаачилж, өргөн барих шийдвэр гаргуулах зорилгоор түүнийг тараана.

4.Хэрэв шинээр сонгогдсон Жогорку Кенешийн депутатууд татан авсан хуулийн төслийг дахин санаачилж, өргөн барихгүй бол түүнийг Жогорку Кенешийн архивд хадгална.

5.Олон нийтийн саначлагаар өргөн барьсан хуулийн төсөл, эсхүл шинэ Засгийн газраас дэмжсэн хуулийн төслийг энэ регламентаар тогтоосон журмын дагуу Жогорку Кенеш хэлэлцэнэ.

6.Өмнөх бүрэн эрхийн Жогорку Кенешийн чуулганаар гурван хэлэлцүүлэг хийгдсэн хуулийн төслийг энэ регламентаар тогтоосон журмын дагуу Жогорку Кенеш хэлэлцэнэ.

51 дүгээр зүйл. Хуулийн төслийг хариуцагч хороо анхны хэлэлцүүлэгт бэлтгэх

5.Хэрэв тухайн хуулийн өөр хувилбар бүхий төслүүд байгаа бол хариуцагч хороо нь тэдгээрийг нэг зэрэг хэлэлцээд, Жогорку Кенешид аль нэг хуулийн төслийг батлах, үлдсэн бусад хуулийн төслөөс татгалзах, эсхүл бүх хуулийн төслүүдийг нэгтгэх, эсхүл бүх хуулийн төслүүдээс татгалзахыг зөвлөнө.

2.БНКИРГИЗ УЛСЫН ЖОГОРКУ КЕНЕШИЙН РЕГЛАМЕНТ²⁹⁰

55 дугаар зүйл. Хуулийн төслийг хэлэлцэхэд тавигдах нийтлэг шаардлага

1.Жогорку Кенеш нь тухайн асуудал хариуцагч хороодоор хэлэлцүүлсний дараа хуулийн төслийг батална.

2.Хариуцагч хорооноос Жогорку Кенешийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн хуулийн төсөл, холбогдох баримт бичгийг Жогорку Кенешийн даргад илгээнэ.

3.Хуулийн төслийг гурван удаа хэлэлцэж батална.

4.Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үндсэн хуульд нэмэлт оруулах тухай, улсын хилийг өөрчлөх тухай хуулиудын төслийг Жогорку Кенеш гурваас доошгүй удаа хэлэлцэж батална. Эдгээр хуулийн төслүүдийг нийт депутатуудын олонхын саналаар

²⁸⁹ О Парламенте Республики Казахстан и статусе его депутатов. Конституционный закон Республики Казахстан от 16 октября 1995 года N 2529. Эх сурвалж: <http://www.parlam.kz/ru/status>

²⁹⁰ Регламент Жогорку Кенеша Кыргызской Республики. Эх сурвалж: <http://www.kenesh.kg/ru/article/show/14/reglament-zhogorku-kenesha-kirgizskoy-respubliki>

дөрөв дэх хэлэлцүүлгийг хийж болно.

5.Улсын төсөвт тусгагдсан зардлыг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг Засгийн газар санхүүжилтийн эх үүсвэрээ тогтоосны дараа Жогорку Кенеш батална.

6.Жогорку Кенеш хуулийн төслүүдийг сарын ажлын төлөвлөгөөний дагуу хэлэлцэнэ.

7.Хуулийн төслийг дагалдах баримт бичигтэй хамт Жогорку Кенешээр хэлэлцэхээс 3-аас доошгүй хоногийн өмнө депутатуудад хүргүүлнэ.

8.Хуулийн төсөл хэлэлцсэний үр дүнд Жогорку Кенеш санал хураалт явуулна.

9.Хуулийн төслийн хэлэлцүүлэг тус бүрийн хооронд энэхүү регламентад зааснаас бусад тохиолдолд ажлын 10-оос доошгүй 30-аас дээшгүй хоног завсарлага авна.

10.Бүх фракц (намын бүлэг, эвсэл), хариуцагч болон холбогдох хороодын дэмжсэн санал гарсан бол Жогорку Кенеш дор дурдсан тохиолдолд хуулийн төслийн гурван хэлэлцүүлгийг нэгэн зэрэг баталж болно.

1)хуулийн хэм хэмжээг Үндсэн хуультай нийцүүлэх;

2)одоо мөрдөж байгаа хуулийг шинээр батлагдсан хуулийн хэм хэмжээтэй нийцүүлэх;

3)хуулийн зарим зүйлийг тухайн хуулийн бусад зүйлд нийцүүлэх;

4)хуулийн үсгийн алдааг зөв бичих дүрмийн дагуу залруулах;

6)зээлийн гэрээнд зааснаас бусад олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэх.

12.Жогорку Кенешээс хуулийн төслийг буцаасан бол ийнхүү Жогорку Кенешийн буцаасан тухай шийдвэр гарснаас хойш 6-аас доошгүй сарын дараа дахин хэлэлцэж болно.

56 дугаар зүйл. Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг

1.Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт хэлэлцэх явцад үзэл баримтлал, зорилго, зорилт, бүтэц, хамаарал, оновчтой байдал, түүнчлэн Үндсэн хуулийн заалтыг дагаж мөрдөх асуудлыг хэлэлцэнэ. Жогорку Кенеш хуулийн төслийн бүх зүйлийг дарааллаар хэлэлцэх эсэхийг шийдвэрлэж болно.

2.Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг энэ регламентын 76 дугаар зүйлд заасан журмын дагуу явуулна.

63 дугаар зүйл. Зөвшилцөх ажлын хэсэг байгуулах, зөвшилцөх ажлын хэсгийн үйл ажиллагаа

1.Жогорку Кенешээс зөвшилцөх ажлын хэсэг байгуулах тухай шийдвэр гаргана. Ийнхүү шийдвэр гаргахдаа ажлын хэсгийн гишүүдийн тоо, бүрэлдэхүүнийг Жогорку Кенеш болон Ерөнхийлөгчийн санал болгосны дагуу тогтооно.

2.Жогорку Кенешээс байгуулсан зөвшилцөх ажлын хэсэгт хуулийн төсөл санаачлагч болон хариуцагч хорооны төлөөллүүд багтана.

3.Зөвшилцөх ажлын хэсгээс шийдвэр гаргахдаа түүний гишүүдийн саналыг “нэг тал - нэг санал” гэсэн зарчмаар явуулна. Зөвшилцөх ажлын хэсгийн санал нэг байна.

4.Зөвшилцөх ажлын хэсэг хуулийн төслийн зөвшилцсөн хувилбар болон өөрчлөлт хийсэн хүснэгтэд гарын үсэг зурахаас өмнө энэ регламентын 50 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан журмыг хэрэгжүүлэхийн тулд экспертийн албанд хүргүүлнэ.

5.Зөвшилцөх ажлын хэсэг нь Жогорку Кенешээс түүнийг байгуулсан шийдвэр гарсан өдрөөс хойш хуанлийн 30-аас доошгүй хоногийн дотор зөвшилцсөн хувилбар болон өөрчлөлт хийсэн хүснэгтийг Жогорку Кенешийн даргад хүргүүлнэ.

6.Зөвшилцөх ажлын хэсгийн үйл ажиллагааны зохион байгуулалт мэдээллийн дэмжлэгийг тухайн хуулийн төслийн хариуцагч хороо гүйцэтгэнэ.

7.Зөвшилцөх ажлын хэсгээс боловсруулсан хувилбарын талаар Жогорку Кенеш шийдвэрлэнэ:

1)Үндсэн хуулийн асуудлаар - нийт депутатуудын олонхын буюу гуравны хоёроос доошгүйн саналаар;

2)бусад хуулийн асуудлаар – хүрэлцэн ирсэн депутатуудын олонхын буюу 50-аас доошгүйн саналаар.

72 дугаар зүйл. БНУ-ын төсвийн тухай хууль батлахад тавигдах шаардлага

1.Бүгд Найрамдах Улсын төсвийн тухай хуулийн төслийг энэ регламентад заасан гурван хэлэлцүүлгээр бүрэн хэлэлцүүлэх журмын дагуу Жогорку Кенеш хэлэлцэнэ.

73 дугаар зүйл. БНУ-ын төсвийн тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийн онцлог

1.Жогорку Кенеш БНУ-ын төсвийн тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийн үед түүний үзэл баримтлал, БНКиргиз Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн төлөв, Бүгд Найрамдах Улсын төсвийн үндсэн шинж чанар, төсөв, татварын бодлогын үндсэн чиглэл, түүний дотор дотоодын нийт бүтээгдэхүүн, инфляцийн түвшингийн талаар хэлэлцэнэ.

2.Жогорку Кенеш хуулийн төсөлд хавсаргасан дараа оны болон түүний дараагийн хоёр жилийн урьдчилсан төлөвийг хэлэлцэнэ.

1)төсвийн орлогын хэмжээ дотоодын нийт бүтээгдэхүүнд болон нийт дүнд эзлэх хувь;

2)төсвийн зарлагын хэмжээ дотоодын нийт бүтээгдэхүүнд болон нийт дүнд эзлэх хувь;

3)төсвийн алдагдал (ашиг)-ын хэмжээ болон түүний дотоодын нийт бүтээгдэхүүнд болон нийт дүнд эзлэх хувь;

4)төсвийн алдагдлыг нөхөх эх үүсвэр;

5)дараа онд болон түүний дараагийн хоёр жилд БНУ болон орон нутгийн төсвийн орлогын хуваарилалт;

6)дараа оны болон түүний дараагийн хоёр жилийн эцэст БНКиргиз Улсын дотоод, гадаад өрийн дээд хязгаар;

7)дараа оны болон түүний дараагийн хоёр жилийн төсөв дэх Засгийн газрын нөөц сангийн норматив утга.

3.БНУ-ын дараа оны болон түүний дараагийн хоёр жилийн төсвийн үндсэн төлөвийг батлахад дараа оны санхүүгийн жилд төсөвлөсөн дотоодын нийт бүтээгдэхүүн, хэрэглээний үнийн инфляцийн түвшинг өмнөх оны 7 дугаар сарын үзүүлэлттэй харьцуулж харуулна.

4.Жогорку Кенеш БНУ-ын төсвийн анхны хэлэлцүүлгийн үед Засгийн газраас санхүүжилтийн эх үүсвэрийг нь тогтоогоогүй улсын төсвийн зардал нэмэхийг хориглоно.

3.ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ТӨРИЙН ДУМЫН РЕГЛАМЕНТ

96 дугаар зүйл. Цахим системийг ашиглах

Төрийн Думд цахим системийг дараах зорилгоор ашиглаж болно:

а) Төрийн Думын гишүүдийг бүртгэх;

б) депутатуудыг үг хэлэх, төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулахаар бүртгэх;

в) санал хураалтын дүнг тоолох, санал хураалтын дүнг гаргах;

г) хуралдааны явцын талаарх мэдээлэл болон статистик мэдээлэл цуглуулах, өгөх;

д) жагсаалтад гарын үсэг зуруулах, хуралдааны бусад баримт бичгийг бүрдүүлэх;

ж) танхимын хуралдааныг мэдээллээр хангах.

111 дүгээр зүйл.

3.Хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Ажлын хэсэг байгуулж болох бөгөөд түүнд тухайн мэргэжлийн хорооны гишүүд орно.

4.Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тухайн мэргэжлийн хорооны гишүүн биш депутат болон мэргэжлийн байгууллагын төлөөлөгч, мэргэжилтэн, шинжээч орж болно.

116 дугаар зүйл.

1.Төрийн Дум хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль болон энэхүү Регламентад өөрөөр заагаагүй бол гурван үе шатаар хэлэлцэнэ.

2.Ээлжит жилийн ОХУ-ын төсвийн тухай, төсвийн бус сангийн тухай хуулийн төслийг ОХУ-ын Төсвийн тухай хууль болон энэ регламентаар тогтоосон журмаар хэлэлцэнэ. ОХУ-ын төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэх журмаар хэлэлцэнэ.

117 дугаар зүйл.

1.Анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн хуулийн төсөл, түүнд холбогдох материалыг Төрийн Думын Тамгын газар ОХУ-ын Ерөнхийлөгч, Холбооны Зөвлөл, Төрийн Думын депутатууд, тухайн хуулийг санаачилсан хууль санаачлах эрх бүхий этгээдэд төслийг хэлэлцэхээс гурваас доошгүй хоногийн өмнө хүргүүлнэ.

2.ОХУ-ын Үндсэн хуулийн 104 дүгээр зүйл /3 дугаар хэсэг/-д зааснаас бусад хуулийн төслийг тухайн төслийн талаар саналаа ирүүлэхээр заасан хугацаанд саналыг ирүүлээгүй бол Төрийн Дум нь Засгийн газрын үнэлгээ болон хууль санаачлах эрх бүхий бусад этгээдийн саналгүйгээр хэлэлцэх эрхтэй.

125 дугаар зүйл.

1.Төрийн Думын Зөвлөл хуулийн төслийг батлахын тулд гурав дахь хэлэлцүүлгийг товлон. Хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийн үеэр төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулсан бол Төрийн Думын Зөвлөл хуулийн төсөл болон Тамгын газрын дүгнэлтийг ОХУ-ын Ерөнхийлөгч, Холбооны Зөвлөл, Засгийн газар, Төрийн Думын депутатуудад хүргүүлнэ.

2.Хуулийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийн үед хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах, төслийг бүхэлд нь буюу түүний хэсэг, зүйл, заалтыг дахин боловсруулахаар хороонд буцаах боломжгүй.

3.Гурав дахь хэлэлцүүлгээр хуулийн төслийг батлаагүй бол түүнийг буцаасанд тооцно. Хуулийн төслийг буцаах тухай шийдвэрийг нэмэлт санал хураалт явуулахгүйгээр Төрийн Думын тогтоол гаргана.

4.Онцгой тохиолдолд Төрийн Дум дахь хамгийн олон депутатыг төлөөлсөн намын бүлгийн шаардсанаар хуралдаан даргалагч хуулийн төслийг хоёр дахь хэлэлцүүлгийн шат руу шилжүүлэхээр санал хураалт явуулж болно.

220 дугаар зүйл.

Төрийн Думаас эцэслэн батлаагүй хуулийн төсөл, Төрийн Дум баталсан боловч Холбооны Зөвлөл буцаасан хуулийн төслийг Төрийн Дум дараагийн чуулганаараа ОХУ-ын Үндсэн хуулиар тогтоосон журмын дагуу хэлэлцүүлэг зогссон шатнаас, Төрийн Думын шинээр сонгогдсон бүрэлдэхүүн өөрөөр шийдвэрлээгүй бол дараагийн сонгуулиар бүрдсэн Төрийн Думын чуулганаар үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

4.ФРАНЦЫН ПАРЛАМЕНТЫН ХУРАЛДААНЫ ДЭГ

84 дүгээр зүйл.

1.Засгийн газар өргөн мэдүүлсэн хуулийн төслөө Парламентаар эцэслэн батлахын өмнөх аль ч шатанд татан авч болно.

2.Хуулийн төсөл санаачлагч, эсхүл нэгдүгээр гарын үсэг зурагч хуулийн төслийн анхны хэлэлцүүлгээр батлагдахаас өмнө аль ч шатанд төслөө татан авч болно. Хэрэв хуулийн төслийг нэгдсэн чуулганаар хэлэлцэж байхад татан авсан бөгөөд өөр нэг гишүүн төслийг хэлэлцүүлэх санал гаргасан тохиолдолд хэлэлцүүлэг цааш үргэлжилнэ.

3.Төслийг Ассамблей буцаасан тохиолдолд нэг жилийн дотор дахин тухайн төслийг өргөн мэдүүлж болохгүй.

85 дугаар зүйл.

1.Ассамблейн Ерөнхийлөгч Ассамблейн Ажлын албанд санаачлан өргөн мэдүүлсэн бүх хууль, шийдвэрийн төслийг холбогдох байнгын хороо, эсхүл тухайн асуудлыг хариуцсан тусгай хороонд шилжүүлнэ

2.Хэрэв байнгын хороо харьяалалгүй гэж үзэн татгалзах эсхүл хоёр буюу хэд хэдэн байнгын хороодын хооронд харьяаллын асуудлаар маргаан үүссэн тохиолдолд Засгийн газар, хуулийн төсөл санаачлагч, эсхүл холбогдох байнгын хороодын дарга нар үг хэлж болох ба хэлэлцүүлгийн эцэст Ерөнхийлөгч хамгийн түрүүнд хариуцах тусгай хороог байгуулахыг санал болгоно. Хэрэв энэ санал дэмжигдээгүй бол Ерөнхийлөгч тухайн асуудлыг хариуцах харьяаллыг тогтоолгохоор Ассамблейд асуулт тавина.

UIH.MN
СҮДАЛГААНЫ САН